



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2020.03.10 № 01/784
танай _____-ны № _____-т

УЛСЫН ИХ ХУРЛЫН 2020 ОНЫ
ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД
ОРОЛЦОХ УЛС ТӨРИЙН НАМ,
ЭВСЛИЙН УДИРДЛАГАД

Мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргах аудитын тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.17, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.5-д "Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн эсэх болон санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцэж байгаа эсэх..."-ийг Төрийн аудитын байгууллага хянаж, дүгнэлт гаргахаар заасан. Энэхүү заалтын дагуу Төрийн аудитын дээд байгууллага сонгуульд оролцох нам, эвслийн мөрийн хөтөлбөрт аудит хийх бэлтгэл ажлыг эхлүүлээд байна.

1. Аудитыг Төрийн аудитын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- 1.1 Улс төрийн нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль болон мөн хуулийн 38 дугаар зүйлийн 38.3-т заасан мөрийн хөтөлбөрт тусгахыг хориглосон заалт байгаа эсэхийг хянах;
- 1.2 Улс төрийн нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.5-д заасанчлан Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн эсэх болон санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд гарах зардлын дүн нь Төсвийн тогтвортой байдлын хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцэж байгааг хянах;
- 1.3 Тодруулах зүйлсийг тухай бүр мэдэгдэх бөгөөд аудитын явцад удирдлагаас нэмэлт мэдээлэл, тайлбар авах;
- 1.4 Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.9-д заасны дагуу сонгуулийн мөрийн хөтөлбөр нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд заасан шаардлага хангаагүй дүгнэлт гарсан тохиолдолд тав хоногийн дотор зөрчлийг арилгасны үндсэн дээр дахин дүгнэлт гаргах болон дээрхтэй холбоотой бусад чиг үүрэг хамаарна.

Нам, эвслээс ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нийцэж байгаа эсэх дүгнэлтийг 2020 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлнэ.

2. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн дагуу нам, эвслийн удирдлага дараах үүрэг хариуцлагыг хүлээж байна. Үүнд:

2.1 Нам, эвсэл нь мөрийн хөтөлбөртөө дүгнэлт гаргуулахаар 03 дугаар сарын 25-ны өдрөөс өмнө Үндэсний аудитын газарт хүргүүлсэн байх; /Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38.6/;

2.2 Нам, эвсэл нь сонгуульд оролцох хүсэлтийг санал авах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө илэрхийлэхдээ дээрх дүгнэлтийг гаргуулсан байх; /Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйл, мөн зүйлийн 26.3.4, 26.4.4/.

2.3 Нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөр болон түүнд дүгнэлт гаргахад шаардагдах мэдээлэл /энэхүү захидлын нэг ба хоёрдугаар хавсралт/ мөн мөрийн хөтөлбөрийн 4 эх хувийг¹ хэвлэмэл байдлаар, хувийг CD-нд буулган дугтуйнд хийж битүүмжлэлтэйгээр Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газар /Засгийн газрын 4 дүгээр байр 4 давхар 407 тоот/ -т ажлын цагаар хүлээлгэн өгнө. Дугтуйн дээр намын нэрийг гаргацтайгаар бичсэн байна.

Аудит гүйцэтгэх хугацаанд сонгуульд оролцох нам, эвсэл дөрвөн жилийн хугацаанд хэрэгжих мөрийн хөтөлбөрийг шаардлагатай баримт, материалын хамт Төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлэх, аудитын зорилгоор хүссэн нэмэлт тайлбар, мэдээллийг бичгээр баталгаажуулж өгөх, аудитын нотолгоог олж авах нөхцөл, боломжоор хангаж ажиллана уу.

Нам, эвсэл нь хуулийн дээрх зохицуулалтуудыг анхаарч мөрийн хөтөлбөрөө хуулийн хугацаанд Үндэсний аудитын газарт ирүүлэх бөгөөд тус чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор тухайн нам, эвслийг төлөөлөн шууд харилцах эрх бүхий албан тушаалтны мэдээллийг нотлох баримтын хамт ирүүлж, уг албан тушаалтан солигдох өөрчлөгдөх бүрд Үндэсний аудитын газарт албан бичгээр мэдэгдэж ажиллахыг хүсье.

Аудитыг хуулиар тогтоосон хугацаанд гүйцэтгэхэд харилцан хүлээсэн үүргээ хэрэгжүүлж хамтран ажиллана гэдэгт итгэж байна.

Хавсралт.....³хуудастай.

Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



О.ТЭНГИС

¹ Мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргасан тайланг эх хувиар 4 газар хэрэглэнэ. 1% -ийг ТАБ-д, 1% -ийг СЕХ-нд, 2% -ийг нам эвсэл, бие даан нэр дэвшигчид баталгаажуулан хүргүүлнэ.

Үндэсний аудитын газрын 2020 оны ... дугаар сарын ...-ний өдрийн ... дугаар албан бичгийн нэгдүгээр хавсралт

**Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.5-д заасан дүгнэлт гаргахтай холбогдуулан
2020 оны УИХ-ын ээлжит сонгуульд оролцох улс төрийн нам, эвслээс мөрийн хөтөлбөрийн талаар
Үндэсний аудитын газарт ирүүлэх мэдээлэл**

№	Нам эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээ	“Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”-ийн холбогдох зүйл, заалт	Зорилт, арга хэмжээг хэрэгжүүлдэхэд санхүүжилт шаардагдах, зардал гаргахаар тусгасан эсэх	Тайлбар
	1	2	ТИЙМ* 3 4	

9006109
9019120396

Жич:

- 2 дугаар баганад Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын ямар заалтыг үндэслэл болгосныг тодорхой бичнэ.

Мэдээллийг бэлтгэсэн _____-ыг төлөөлж
 (тэмдэг) _____ Нам/эвслийн/нэр _____-ыг төлөөлж
 албан тушаал овог нэр гарын үсэг
 (тэмдэг) _____-ыг төлөөлж
 албан тушаал овог нэр гарын үсэг

2020 оны ... сарын ... өдөр

Үндэсний аудитын газрын 2020 оны
3 дугаар сарын 18-ний өдрийн дугаар
албан бичгийн хоёрдугаар хэсрэлт

**Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 18.2.5-д заасан дүгнэлт гаргахтай холбогдуулан
2020 оны УИХ-ын ээлжит сонгуульд оролцох улс төрийн нам, эвслээс мөрийн хөтөлбөрийн талаар
Үндэсний аудитын газарт ирүүлэх мэдээлэл**


№	Нам эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгагдсан санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээ	Шаардагдах санхүүгийн эх үүсвэрийн эрх зүйн үндэслэл				Шаардагдах санхүүгийн эх үүсвэрийн хэмжээ (тэрбум төгрөгөөр)				Зардлын дүн жил тус бүрээр (тэрбум төгрөгөөр)	Тайлбар
		Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн холбогдох заалт*/18 дугаар зүйлийн 18.2.1-18.2.5/	Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан холбогдох үзүүлэлт	Тусгасан зардалд 2021-2022 оны төсвийн төсөөллийг баримталсан эсэх (Тийм*, үгүй)	Тусгасан зардалд 2023-2024 оны төсвийн төсөөллийн тооцоолол гаргасан эсэх (Тийм*, үгүй)	6	7	8	9		
1			3	4	5	6	7	8	9	10	
Нийт дүн											

Жич:

- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.6-д зааснаар бусад орлогоос мөрийн хөтөлбөрт тусгасан зардалд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг тооцсон тохиолдолд үндэслэл бүхий тайлбар, нотлох зүйлийн хамт гаргаж ирүүлнэ.
- 4, 5 дугаар баганад ***Тийм** гэх тохиолдолд мөрийн хөтөлбөрт тусгасан зардлын дагуу төсвийн төсөөллийн тооцоолол **хийсэн бол 3 дугаар хэсрэлт маягтын дагуу задаргааг гаргаж ирүүлнэ /заавал шаардахгүй/.**

Мэдээллийг бэлтгэсэн _____ -ыг төлөөлж
 (тэмдэг) _____ Нам/эвслийн/нэр
 албан тушаал овог нэр -ыг төлөөлж
 (тэмдэг) _____ овог нэр
 албан тушаал овог нэр
 2020 оны ... сарын ... өдөр

3 Үндэсний аудитын газрын 2020 оны
 3 дугаар сарын 10-ний өдрийн 11 дугаар
 албан бичгийн гуравдугаар хавсралт



Нам, эвслийн мөрийн хөтөлбөрт тусгасан санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүнгээс хамааруулан төсвийн төсөөллийн тооцоолол хийсэн бол задаргааг гаргаж ирүүлэх маягт /заавал шаардахгүй/.

Д/д	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	Төсвийн хүрээний мэдэгдэл	2021-2020 оны төсвийн төсөөллийн өөрчлөх дүн			Нам эвслийн тооцоолсон төсвийн төсөөлөл	
			2020	2021	2022	2023	2024
1	Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ /хувь/						
2	Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин						
3	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/ Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь						
4	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/ Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь						
5	Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ /тэрбум төгрөг/ Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь						
6	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/ Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь						
7	Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/ Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь						
8	Засгийн газрын өрийн нийт хэмжээ, өнөөгийн үнэ цэнээр /тэрбум төгрөг/ Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь						
9	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/ Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь						